



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/245

Чингис хот

“Тогтвортой хөгжлийн боловсрол-II”
төслийг хэрэгжүүлэх “Орон нутаг дахь техникийн
зөвлөн зохицуулах баг” томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын “а”, Боловсролын тухай хуулийн 30.1.5, 30.1.16 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 209 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яам, Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам, Швейцарын хөгжлийн агентлагаас хамтран хэрэгжүүлж буй “Тогтвортой Хөгжлийн боловсрол-II” төслийн орон нутаг дахь Техникийн Зөвлөн Зохицуулах багийг дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Багийн ахлагч:	Г.Лхагвахатан	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Д.Болорчимэг	Боловсрол, соёл, урлагийн газрын байгалийн ухааны судлагдахуун, тогтвортой хөгжлийн боловсрол хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	С.Мөнхцэцэг	Боловсрол, соёл, урлагийн газрын дарга
	Б.Дархантөр	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
	Д.Өнөрцэцэг	Нийгмийн бодлогын хэлтсийн боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн
	Д.Отгонцолмон	Мэргэжлийн хяналтын газрын Боловсрол, соёлын хяналтын улсын байцаагч
	З.Мөнхнасан	Насан туршийн боловсролын төвийн Нийгмийн ажилтан
	Э.Оюумаа	Хэрлэн голын сав газрын Усны нөөцийн нэгдсэн менежмент, төлөвлөлт, олон нийт, сургалт хариуцсан мэргэжилтэн
	М.Золзаяа	Тэмүүжин цогцолбор сургуулийн захирал
	К.Түмэндэлгэр	Хан Хэнтий цогцолбор сургуулийн захирал
	О.Баярмаа	Галшар сумын Ерөнхий боловсролын

101116677

	2. сургуулийн захирал
Д.Дамдинпүрэв	Дадал сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал
Б.Анхбаяр	Баян-Адарга сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал
Ө.Одмаа	“Өндөрхаан” телевизийн захирал
Б.Цэрэнчимэд	“ХЭННЭС” “Хэнтий аймгийн ногоочдын нэгдсэн сүлжээ” төрийн бус байгууллагын удирдах зөвлөлийн захирал
Ш.Цолмон	Хан Хэнтий тусгай хамгаалалттай газрын захиргааны Мэдээлэл сургалт хариуцсан мэргэжилтэн
П.Гансүх	Онон балжийн тусгай хамгаалалттай газрын захиргааны Мэдээлэл сургалт хариуцсан мэргэжилтэн

2. “Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төслийг орон нутгийн хэмжээнд үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газар /С.Мөнхцэцэг/, Байгаль орчин, аялал жуулчлалын газар /Б.Дархантөр/-т, төслийг хэрэгжүүлэх ажлыг бодлого, зохион байгуулалт, мэргэжил арга зүйгээр хангаж, бусад шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллахыг багийн гишүүдэд тус тус үүрэг болгосугай.

3. Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр батлан хэрэгжилтийг тооцож, тайланг холбогдох газарт цаг тухайд нь хүргүүлж ажиллахыг багийн ахлагч /Г.Лхагвахатан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА